


ИНФОГРАФИК: ГОЛЛОХ ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Өмнөх сартай харьцуулсан үзүүлэлт



ЭКСПОРТЫН ГОЛ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ХЭМЖЭЭ БОЛОН ДУНДАЖ ҮНЭ



Экспортын гол бүтээгдэхүүний хэмжээ болон дундаж үнийг графикаар оны эцсийн байдлаар харуулав.



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

ИНФОГРАФИК- САР ТУТМЫН БУСАД ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Өмнөх сартай харьцуулсан үзүүлэлт



ЭДИЙН ЗАСАГ ЯМАР БАЙХ ВЭ?- ТААМАГ (ОУЭЗБ)

ДНБ-ий өсөлт: 2019 онд: **+6.1%**
Инфляци: 2019 онд: **+7%**

Урсгал тэнцэл: 2019 онд: ДНБ-ий **-7%**-тай байхыг Азийн хөгжлийн банк (АЗХБ) 2018 оны тайланд тоймлосон байна.

Эх сурвалж: <https://bit.ly/2HJFlip>

ДНБ-ий өсөлт: 2019 онд: **+6.3%**
Инфляци: 2019 онд: **+6.8%**,


ДНБ-д эзлэх урсгал тэнцэл: 2019 онд: **-8.3%**- Олон улсын валютын сан (ОУВС)-аас гаргадаг (Дэлхийн эдийн засгийн төлөв байдлын судалгаа, 2018 он 4-р сар) тайланд дурдсан байна.

Эх сурвалж: <http://bit.ly/2zsmvYo>

ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД: УЛСЫН ТӨСӨВ, ВАЛЮТЫН ХАНШ, ИНФЛЯЦИ, ГАДААД ХУДАЛДАА

Төсвийн тэнцэл 1-р сарын байдлаар 132 тэрбум төгрөгийн ашигтай гарав.

Улсын нэгдсэн төсвийн орлого өнгөрсөн жилийн мөн үеэс 30.2 хувиар, зарлага 34.1 хувиар тус тус өссөн бол төсвийн тэнцвэржүүлсэн нийт тэнцэл 132 тэрбум төгрөгийн ашигтай гарав. Төсвийн алдагдал өнгөрсөн оны мөн үеэс 18.1 тэрбум төгрөгөөр өссөн үзүүлэлттэй байна.



Ам.долларын ханш өмнөх сараас 12.33 төгрөгөөр нэмэгдэв.

Нэгдүгээр сард Монголбанкны төгрөгийн ам.доллартай харьцах нэрлэсэн дундаж ханш өнгөрсөн оны мөн үеэс 223 төгрөг буюу 9.2 хувиар нэмэгдэж, өмнөх сартай харьцуулахад 12.33 төгрөг буюу 0.4 хувиар нэмэгдэж 2649.68 төгрөг болов. 1-р сард гадаад валютын нөөц 3.6 тэрбум төгрөг буюу өнгөрсөн сараас 2 хувиар, өмнөх оны мөн үеэс 29 хувь нэмэгдсэн байна.




Инфляцийн түвшин 7.3%

Хэрэглээний үнийн индекс улсын хэмжээнд 2019 оны 1-р сарын байдлаар өмнөх сараас 0.6 хувиар өсч, өмнөх оны мөн үеэс 0.6 хувиар, оны эхнээс 7.3 хувь өсөв. Хүнсний бараа, орон сууц, ус, цахилгаан, хувцас, эм тариа, эмнэлгийн үйлчилгээний бүлгийн үнэ өссөн нь голлон нөлөөлжээ.




Гадаад худалдааны тэнцэл 103.3 сая.ам доллар болов.

2019 оны нэгдүгээр сарын байдлаар нийт барааны эргэлт 1111.2 тэрбум төгрөг буюу өмнөх оны мөн үеэс 41.5 хувиар өссөн бол экспорт өмнөх сараас 43.2 импорт өмнөх оны мөн үеэс 35.5 хувиар өсч гадаад худалдааны тэнцэл 103.3 сая ам.долларын ашигтай гарлаа.



1-Р САРЫН ОНЦЛОХ: ХАДГАЛАМЖ

Эх сурвалж: www.1212.mn

Нийт хадгаламж 2019 оны 1-р сард 13.1 их наяд төгрөг болж өмнөх сараас 49.9 тэрбум төгрөг буюу 0.2 хувиар нэмэгдэв. Энэ нь өнгөрсөн оны мөн үеэс 18.7 хувиар буюу 2070 тэрбум төгрөгөөр өсөв. Тус сард төгрөгийн хадгаламж 10180 тэрбум төгрөг буюу өмнөх сараас 0.2 хувиар нэмэгдсэн бол валютын хадгаламж 2945.5 тэрбум төгрөг болж өмнөх сараас 2.5 хувиар буурчээ. Үүнээс төгрөгийн хадгаламж 78 хувь, валютын хадгаламж 22 хувийг эзэлж байна. Харин өнгөрсөн оны мөн үеэс төгрөгийн хадгаламж 17.7 хувиар нэмэгдсэн бол валютын хадгаламж 22.5 хувийг эзэлж байна.

САРЫН ОНЦЛОХ: ЭРДЭНЭС ТАВАНТОЛГОЙ НОГДОЛ АШИГ, АЙМГУУДЫН ӨРСӨЛДӨХ ЧАДВАРЫН СУДАЛГААНЫ ТАЙЛАН 2018 ГАРАВ.

- Төрийн өмчит “Эрдэнэс Тавантолгой” ХК 2018 онд 720 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай ажилласан тул хөрөнгийн зах зээлд IPO хийж хувьцаагаа гаргахаас өмнө ногдол ашгаа хуваарилж олгохоор болжээ. Ногдол ашгийг тус компанийн 1072 ширхэг хувьцааг эзэмшиж буй Монгол Улсын иргэн бүр буюу 2.5 сая иргэн хүртэнэ. Хэдэн төгрөгийн ногдол ашиг олгохыг энэ оны 4-р сард болох Хувьцаа эзэмшигчдийн хурлаар шийдэж, Засгийн газарт хүргүүлсний дараа тодорхой болох юм байна.
- Эдийн засгийн бодлого, өрсөлдөх чадварын судалгааны төвөөс жил бүр гаргадаг “Аймгуудын өрсөлдөх чадварын тайлан-2018”-гийн үр дүнг танилцуулав. Тайлангийн үр дүнгээс харахад, Орхон, Дархан-Уул, Өмнөговь аймгууд өрсөлдөх чадвараараа тэргүүлжээ. Харин сүүлийн байруудад Дундговь, Говь-Алтай, Архангай аймгууд эрэмбэлэгдсэн байна. Өрсөлдөх чадварыг хэмждэг үндсэн дөрвөн бүлгийн нэг буюу эдийн засгийн тамир тэнхээгээр Орхон, Өмнөговь, засаглалын үр ашгаар Говьсүмбэр, Сүхбаатар аймгууд тэргүүлжээ. Мөн бизнесийн үр ашгаар Дархан-Уул, Өмнөговь аймгууд, дэд бүтцээр Орхон, Говьсүмбэр аймгууд тэргүүлсэн байна. Тайлантай дэлгэрэнгүй танилцах бол: www.aimagindex.mn хаягаар зочилно уу.

Эх сурвалж:

1. Статистикийн бюллетень, 1-р сар 2019 он, Үндэсний статистикийн хороо
2. Статистикийн бюллетень, 1-р сар 2019 он, Монголбанк
3. www.1212.mn, www.mongolbank.mn, www.montsame.mn